



I-IV/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 14



## МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААС

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2021 оны 4 дүгээр сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 26.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.4 (31.4 %) их наяд төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 0.7 (19.9%) их наяд төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 4.1 (38.6%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Бага мөнгө (M1) 2021 оны 4 дүгээр сарын эцэст 5.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 800.8 (18.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1.7 (49.7%) их наяд төгрөгөөр өссөн байна. Бага мөнгө (M1)-ний 4.3 (83.8%) их наяд төгрөг нь төгрөгийн харилцах, 0.8 (16.2%) их наяд төгрөг нь хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө байна.

Бараг мөнгө 2021 оны 4 дүгээр сарын эцэст 21.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 652.2 (3.1%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4.7 (27.7%) их наяд төгрөгөөр өссөн байна. Бараг мөнгөний 14.7 (68.5%) их наяд төгрөг нь төгрөгийн хадгаламж, 4.5 (21.0%) их наяд төгрөг нь валютын хадгаламж, 2.3 (10.6%) их наяд төгрөг нь валютын харилцах байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2021 оны 4 дүгээр сарын эцэст 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 78.2 (7.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 225.7 (26.3%) тэрбум төгрөгөөр өсжээ.

### Хүснэгт 1. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт

	2019 IV	2020 IV	2021*		2021*IV	2021*IV
			III	IV	2020 IV	2021* III
	тэрбум төгрөг				хувь	
Мөнгө M2	19 909.5	20 230.8	25 136.0	26 589.0	131.4	105.8
Бага мөнгө M1	3 671.1	3 425.5	4 328.0	5 128.8	149.7	118.5
Төгрөгийн харилцах	3 030.8	2 837.8	3 588.9	4 298.8	151.5	119.8
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	640.3	587.6	739.1	830.0	141.3	112.3
Бараг мөнгө	16 238.4	16 805.4	20 807.9	21 460.2	127.7	103.1
Төгрөгийн хадгаламж	10 978.6	10 602.3	14 171.4	14 695.5	138.6	103.7
Валютын хадгаламж	2 863.3	3 750.4	4 375.2	4 497.4	119.9	102.8
Валютын харилцах	2 396.4	2 452.7	2 261.4	2 267.3	92.4	100.3
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	933.0	858.5	1 006.0	1 084.1	126.3	107.8

Зураг 1. Төгрөгийн болон валютын хадгаламж, сар бүрийн эцэст, тэрбум төгрөг



Төгрөгийн хадгаламж 2021 оны 4 дүгээр сарын эцэст 14.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 524.1 (3.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4.1 (38.6%) их наяд төгрөгөөр өсжээ.

Төгрөгийн хадгаламжийн 88.6 хувь (13.0 их наяд төгрөг) нь иргэдийн хадгаламж, 11.4 хувь (1.7 их наяд төгрөг) нь аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж байна.

Валютын хадгаламж 4.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 122.3 (2.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 747.0 (19.9%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 4 дүгээр сарын эцэст 17.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 20.0 (0.1%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 485.8 (2.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.9 (50.6%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 4 дүгээр сарын эцэст 14.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 42.9 (0.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 383.7 (2.7%) тэрбум төгрөгөөр өсжээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 81.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.


Хүснэгт 2. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, сарын эцэст

	2019 IV	2020 IV	2021*		2021* IV	2021* IV
			III	IV	2020 IV	2021* III
	тэрбум төгрөг				хувь	
Зээлийн өрийн үлдэгдэл	17 668.6	17 170.6	17 636.4	17 656.4	102.8	100.1
Хэвийн зээл	14 738.4	13 992.4	14 333.2	14 376.1	102.7	100.3
Хугацаа хэтэрсэн зээл	980.3	1 307.0	1 282.5	1 286.0	98.4	100.3
Чанаргүй зээл	1 949.9	1 871.2	2 020.7	1 994.3	106.6	98.7

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 4 дүгээр сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 3.5 (0.3%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 21.0 (1.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны 4 дүгээр сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 26.4 (1.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 123.1 (6.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн байна.

Зураг 2. Чанаргүй зээл, сар бүрийн эцэст, тэрбум төгрөг



Хүснэгт 3. Арилжааны банкнуудаас иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст

	2020	2021*		2021* III	2021*III
	III	II	III	2020 III	2021* II
	тэрбум төгрөг			хувь	
Бүгд	8 477.3	8 483.5	8 852.4	104.4	104.3
Бизнесийн зээл	3 208.4	3 717.3	3 966.0	123.6	106.7
Цалингийн зээл	2 995.3	2 699.0	2 702.5	90.2	100.1
Тэтгэврийн зээл	160.7	147.9	153.0	95.2	103.4
Картын зээл	261.9	211.7	217.4	83.0	102.7
Автомашинны зээл	275.0	230.5	224.3	81.6	97.3
Хадгаламж, данс барьцаалсан зээл	556.2	530.1	617.1	111.0	116.4
Өрхийн хэрэглээний зээл		58.8	58.2	-	99.0
Малчны зээл	-	753.5	764.8	-	101.5
Бусад	1 019.8	134.8	149.1	14.6	110.6

Арилжааны банкнуудаас иргэдэд олгосон зээл 2021 оны 3 дугаар сарын эцэст 8.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 368.9 (4.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 375.1 (4.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Иргэдэд олгосон зээлийн 44.8 хувийг бизнес эрхлэх зээл, 30.5 хувийг цалингийн зээл, 8.6 хувийг малчны зээл, 7.0 хувийг хадгаламж, данс барьцаалсан зээл, 2.5 хувийг автомашинны зээл, 2.5 хувийг картын зээл, 1.7 хувийг тэтгэврийн зээл, 0.7 хувийг өрхийн хэрэглээний зээл, 1.7 хувийг бусад зээл тус тус эзэлж байна.

Иргэдэд олгосон хугацаандаа байгаа 8.1 их наяд төгрөгийн зээлийн 12.1 хувь нь 1 жилийн, 54.1 хувь нь 1-5 хүртэлх жилийн, 33.8 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай байна.

Хүснэгт 4. Арилжааны банкнуудаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлт, сарын эцэст

	2020	2021*		2021* III	2021* III
	III	II	III	2020 III	2021* II
	сая төгрөг			хувь	
Иргэдийн зээлийн эргэн төлөлт	608 605.7	643 265.1	853 130.3	140.2	132.6
Цалингийн зээл	159 682.1	132 119.8	166 219.0	104.1	125.8
Тэтгэврийн зээл	-	27 181.7	35 114.3	-	129.2
Картын зээл	101 956.1	120 798.6	88 322.9	86.6	73.1
Автомашинны зээл	7 808.7	8 281.5	10 822.6	138.6	130.7
Өрхийн хэрэглээнд зориулсан зээл	-	3 925.9	5 416.8	-	138.0
Сургалтын зээл (гадаад)	-	5.7	2.7	-	46.8
Малчны зээл	-	24 239.2	34 120.3	-	140.8
Хадгаламж, данс барьцаалсан зээл	175 571.5	163 300.6	256 805.1	146.3	157.3

Арилжааны банкнуудаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлт 2021 оны 3 дугаар сарын эцэст 853.1 тэрбум төгрөгт болж, өмнөх сараас 209.9 (32.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 244.5 (40.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зээлийн эргэн төлөлтийн 30.1 хувийг (256.8 тэрбум төгрөг) хадгаламж, данс барьцаалсан зээл, 19.5 хувийг (166.2 тэрбум төгрөг) цалингийн зээл, 10.4 хувийг (88.3 тэрбум төгрөг) картын зээл, 4.1 хувийг (35.1 тэрбум төгрөг) тэтгэврийн зээл, 4.0 хувийг (34.1 тэрбум төгрөг) малчны зээл, 1.3

хувийг (10.8 тэрбум төгрөг) автомашины зээл, 0.6 хувийг (5.4 тэрбум төгрөг) өрхийн хэрэглээнд суурилсан зээл, 30.0 хувийг (256.3 тэрбум төгрөг) бизнесийн зээл тус тус эзэлж байна.

Жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээл 2021 оны 3 дугаар сарын эцэст 4.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 381.3 (9.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 342.7 (8.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Арилжааны банкнуудаас жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст

	2020	2021*	2021*	Иргэд	Аж ахуйн нэгж
	III	II	III		
	тэрбум төгрөг				
Бүгд	3962.2	3923.7	4 304.9	1 896.3	2 408.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	165.6	163.2	177.2	65.6	111.7
Боловсруулах үйлдвэрлэл	567.1	475.5	483.6	77.4	406.2
Барилга	449.7	443.3	451.7	63.8	388.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1283.8	1104.5	1 259.9	753.7	506.3
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	374.8	235.0	273.8	115.0	158.8
Бусад	1121.4	1502.0	1 658.6	820.9	837.7

Жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар нь авч үзвэл, 29.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 11.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 10.5 хувь нь барилга, 6.4 хувь нь байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа, 4.1 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 38.5 хувь нь бусад салбарынх байна.

Арилжааны банкнууд болон Монголын Ипотекийн корпорац (МИК)-аас иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 3 дугаар сарын эцэст 5.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 73.1 (1.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 380.0 (8.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст

	2020 III	2021*		$\frac{2021^* \text{ III}}{2020 \text{ III}}$ %	$\frac{2021^* \text{ III}}{2021^* \text{ II}}$ %
		II	III		
Иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	4 640.3	4 947.2	5 020.3	108.2	101.5
Иргэдэд олгосон ипотекийн зээлийн дансны тоо, мянган ширхэг	97.1	100.6	100.9	103.9	100.3

Үнэт цаасны арилжаагаар 2021 оны эхний 4 сард 599.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 312.3 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 587.8 (50.7 дахин их) тэрбум төгрөгөөр, арилжсан үнэт цаас 254.1 (5.4 дахин их) сая ширхгээр тус тус өссөн байна.

Үнэт цаасны гүйлгээ 2021 оны 4 дүгээр сард 533.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 509.7 (22.2 дахин их) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 531.4 (234.0 дахин их) тэрбум төгрөгөөр өссөн байна. Харин арилжсан үнэт цаас 66.6 сая ширхэг болж, өмнөх сараас 1.3 (1.8%) сая ширхгээр буурч, өмнөх оны мөн үеэс 57.1 (7.0 дахин их) сая ширхгээр өссөн байна.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2021 оны 4 дүгээр сард 35351.5 нэгж болж, өмнөх сараас 1399.2 нэгжээр, өмнөх оны мөн үеэс 18720.3 нэгжээр өссөн байна.

Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2021 оны 4 дүгээр сарын эцэст 3.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 27.1 (0.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1.3 (53.2%) их наяд төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 7. Үнэт цаасны зах зээлийн үзүүлэлт

	2020		2021*		2021* IV	2021* I-IV
	IV	I-IV	IV	I-IV	2020 IV	2020 I-IV
Үнэт цаасны гүйлгээ, сая төгрөг	2 281.1	11 835.4	533 685.1	599 612.5	234.0 <sup>1</sup>	50.7 <sup>1</sup>
ЗГ-ын үнэт цаасны хоёрдогч захын арилжаа, сая төгрөг	-	-	-	-	-	-
Арилжсан үнэт цаас, мянган ширхэг	9 479.4	58 197.5	66 606.5	312 274.6	7.0 <sup>1</sup>	5.4 <sup>1</sup>
ТОП-20 индекс, дундаж	16 631.2	-	35 351.5	-	2.1 <sup>1</sup>	-
Зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөг	2 427.9	-	3 719.1	-	153.2	-

<sup>1</sup> Дахин их

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2021 оны 4 дүгээр сард 2849.89 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар, өмнөх сараас 0.01 хувиар суларсан байна.


Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2021 оны 4 дүгээр сард 437.01 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар суларч, өмнөх сараас 0.2 хувиар чангарсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2021 оны 4 дүгээр сард 37.45 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар суларч, өмнөх сараас 2.2 хувиар чангарсан байна.

#### Хүснэгт 8. Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах сарын дундаж ханш, төгрөгөөр

Үзүүлэлт	2018 IV	2019 IV	2020 IV	2021 IV
Америк доллар	2 394.65	2 634.93	2 783.16	2 849.89
Жилийн өөрчлөлт, хувиар	-1.1	10	5.6	2.4
Сарын өөрчлөлт, хувиар	0.03	0.1	0.5	0.01
Евро	2 941.41	2 961.39	3 024.66	3 408.12
Жилийн өөрчлөлт, хувиар	13.4	0.7	2.1	12.7
Сарын өөрчлөлт, хувиар	-0.4	-0.6	-1.4	0.5
Юань	380.11	392.28	393.46	437.01
Жилийн өөрчлөлт, хувиар	8.2	3.2	0.3	11.1
Сарын өөрчлөлт, хувиар	0.3	-0.01	-0.3	-0.2
Рубль	39.4	40.78	37.06	37.45
Жилийн өөрчлөлт, хувиар	-8.1	3.5	-9.1	1.1
Сарын өөрчлөлт, хувиар	-6.1	0.7	-1.1	-2.2

Зураг 3. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сараар



**Ойлголт, тодорхойлолт:**

**Бага мөнгө /M1/:** Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

**Мөнгөний нийлүүлэлт /M2/:** Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно. Өөрөөр хэлбэл, бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно. Зөвхөн цэвэршүүлсэн алтны харилцах дансны үлдэгдлийг хамруулах бөгөөд бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдлийг хамруулахгүй.

**Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө:** Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс банкнуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасна.

**Бараг мөнгө:** Төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

**Валютын харилцах:** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

**Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө:** Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

**Төгрөг болон валютын хадгаламж:** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

**Үнэт цаас:** Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсвэл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг (опцион), хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийн тухай” Монгол Улсын хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг ойлгоно.

**Хувьцаа:** Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан бүүлгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

**Брокерын үйл ажиллагаа:** Үнэт цаасны зах зээлд бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг ойлгоно.

**Дилерийн үйл ажиллагаа:** Үнэт цаасны зах зээлд ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг ойлгоно.

**Бүртгэлтэй компани:** Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцааны арилжааг идэвхтэй хийдэг хувьцаат компанийг тоог хамруулна.

**Хэлцэл:** Үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалахыг ойлгоно.

**Зах зээлийн үнэлгээ:** Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн нийтэд гаргасан үнэт цаасны тоо, тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшны үржвэрээр тодорхойлно.

**Өрийн бичиг (бонд):** Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

**ТОП 20 индекс:** Үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралтаар үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлно.

**Хэвийн зээл:** Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

**Хугацаа хэтэрсэн зээл:** Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

**Чанаргүй зээл:** Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

### Тооцох аргачлал:

ТОП 20 индексийг дараах томъёогоор тооцно.

$$I = \frac{P}{C} * 100$$

I – Тухайн өдрийн индекс

P – Тухайн өдрийн зах зээлийн үнэлгээ

C – Зах зээлийн суурь үнэлгээ

**Эх үүсвэр:** Монголбанкны мөнгөний статистикийн мэдээлэл, Монголын Хөрөнгийн биржийн сарын мэдээлэл

**Ангилал, код:** ҮСХ, “Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал” 2010 он

**Тайлбар:**

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 6 дугаар сарын 15

**Хавсралт:**

*Эдийн засгийн статистикийн газрын*

*дарга Э.Эрдэнэсан*

*Утас: (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын*

*статистикч А.Мөнхцэцэг*

*Утас: (976-51)-261565*

